

2009 оны 12 сарын 2 ны өдөр

Улсын бүртгэлийн дугаар 004

ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТТАЙ АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГАД ГАЗАР АШИГЛУУЛАХ ГЭРЭЭ

2009 оны 12 сарын 2 ны өдөр

Дарьга аймаг, хот, сум

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Газрын тухай хууль, 1019 аймаг /нийслэл/-ийн Дарьга сум /дүүрэг/-ийн засаг даргын 2009 оны 12 сарын 2 ны өдрийн 127 тоот шийдвэрийг үндэслэн газар өмчлөгчийг төлөөлж Дарьга сум /дүүрэг/-ийн газрын асуудал эрхэлсэн албан тушаалтан Заарбайда овогтой Энхболд газар ашиглагчийг төлөөлж /"МОНКО" - ХХК - ийг /

/аж ахуйн нэгжийн нэр/

Залуул ажилтай Галдосум овогтой Нарангуй нар энэхүү гэрээг байгуулав.

Энэхүү гэрээнд гэрээний салашгүй хэсэг болох дараах зүйлийг заавал тусгах бөгөөд эдгээрийн бүрдэл дутуу бол гэрээг хүчингүйд тооцох үндэслэл болно. Үүнд:

- 1.1 Газрын байршил, хэмжээ, хил хязгаар, заагийг тодорхой харуулсан кадастарын зураг;
- 1.2 Газар өмчлөгчөөс газар ашиглагчид тус газрыг хүлээлгэн өгсөн тухай акт
- 1.3 Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг зохих журмын дагуу хийлгүүлж баталгаажуулсан баримт;

Хоёр. Гэрээний нөхцөл

2.1 Газар ашиглагчид олгосон газрын нийт хэмжээ 208 га. Үүнээс:

Нэгж талбайн тодорхой хэсгийн ашиглах зориулалт	Тухайн зориулалтаар ашиглах газрын хэмжээ
1. Уурхайн талбай (НС-Т-09-012)	30,45 га
2. Уурхайн талбай (НС-Т-09-013)	56,78 га
3. Уурхайн талбай (НС-Т-09-014)	3,22 га
4. Уурхайн талбай (НС-Т-09-015)	46,67 га
5. Уурхайн талбай (НС-Т-09-016)	35,36 га
6. Уурхайн талбай (НС-Т-09-017)	35,09 га

WWW.ILTODGEREE.MN  
ЭХ СУРВАЛЖ

2.2 Газрын төлбөрийн хэмжээ:

Нэгжийн үнэ 8000 төгрөг /үсгээр/...../

Бүгд үнэ 1664000 төгрөг /үсгээр/...../

Үүнээс:

1-р улиралд ..... төг

3-р улиралд ..... төг

2-р улиралд ..... төг

4-р улиралд ..... төг

2.3 Ариун сан 160400995 тоот дансанд шилжүүлж байна.  
/Банкны салбарын нэр, дансны дугаар/

2.4 Газар ашиглуулах тухай эрх бүхий засаг даргын шийдвэр гарсан өдрөөр газрын төлбөр хийх хугацааг тогтооно.

2.5 Эрх бүхий байгууллагын шийдвэрээр газрын төлбөрийн хэмжээ өөрчлөгдөх тохиолдолд гэрээнд өөрчлөлт оруулна. Ийнхүү газрын төлбөрийг шинчлэн тогтоолгоогүй бол зохих зардлыг газар ашиглагч хүлээнэ.

Гурав. Газар ашиглагчийн эрх, үүрэг

3.1 Гэрээний нөхцлийн дагуу газрыг ашиглах;

3.2 Газар өмчлөгчөөс газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг гаргуулж авах;

3.3 Гэрээнд үүргээ зохих ёсоор биелүүлж ирсэн бол эрхийн гэрчилгээний хугацаа дуусахад уг газрыг үргэлжлүүлэн ашиглахаар эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулах;

3.4 Газрын төлбөрийг газрын ашигт шинж чанарыг ашигласан эсэхээс үл хамааран хугацаанд нь төлөх;

3.5 Төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд гүйцэгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,5 хувиар хэтэрсэн хоног тутумд алданги төлөх;

3.6 Газар өмчлөгчөөс газрын ашиглалттай холбогдуулан тавьсан шаардлагыг цаг тухайд нь биелүүлэх;

3.7 Холбогдох хууль тогтоомжоор тогтоосон бусад эрх, үүрэг, хариуцлага хүлээх;

Дөрөв. Газар ашиглуулагчийн эрх, үүрэг

4.1 Газрыг гэрээнд заасан зриулалтын дагуу ашиглаж байгаа эсэхийг хянах;

4.2 Уг газрыг ашиглуулахын зэрэгцээ дараахь шаардлагыг газар ашиглагчид тавих эрхтэй.

Үүнд:

*Уг газрын зориулалтын дагуу ашиглах, нөхөн сэтгэхийг цаг тухайд нь хянах, гэрээнд заасан үүрэг биелүүлж байх, гэрээний төлбөрийн хэмжээг амжилттай төлөхөд тус болгох зориулалтын үүрэгтэй тусгаарласан шаардлагыг биелүүлэх.*

"Газрын тухай" хуулийн 35.3.1.-35.3.6.-д заасан үүргээ гүйцэтгээгүй, энэ талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцалж, мөн хуулийн 62 дугаар зүйлд зааснаар хохирлыг нөхөн төлөхийг шаардах,

4.4 Газар ашиглуулах гэрээг жил бүр дүгнэх;

WWW.ILTODGEREE.MN  
ЭХ СУРВАЛЖ

4.5 Холбогдох хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх, үүрэг, хариуцлага хүлээх;

Тав. Газрын талаарх эд хөрөнгийн эрхийн зарим зохицуулалт

5.1 Газар ашиглагчийн өмчлөлд байгаа тухайн газар дээрх үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх өөр этгээдэд шилжвэл..... *Газрын тухай хуулийн 38, 47-р зүйлээр* ..... шийдвэрлэнэ.

5.2 Энэхүү гэрээгээр ашиглах газрыг хязгаартай ашиглах эрх бүхий газар ашиглагч байгаа болон ийнхүү ашиглахаар шаардсан бол түүний газар ашиглах нөхцөл, журам нь..... *Газрын тухай хуулийн 48-р зүйлээр* .....

5.3 Гэрээний талууд шаардлагатай гэж үзсэн бусад нөхцөл..... *Тухайн газрын зориулалтын дагуу ашигласан бусад хэвцэг, хяналт, шалгалт яшиг шаардагдан зогсон газар ашиглагч байгууллага хариуцна* .....  
Бусад зүйл

6.1 Гэрээ нь газар ашиглагчид газрыг актаар хүлээлгэн өгч, эрх бүхий засаг дарга газар ашиглах эрхийн гэрчилгээ олгосон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж мөрдөгдөнө.

6.2 Энэхүү гэрээг хоёр хувь үйлдэж, талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн..... *Төрийн* үсгээр жилийн хугацаатай байгуулав.

6.3 Энэхүү гэрээтэй холбоотой бусад асуудлыг МУ-ын холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

Гэрээний талуудын албан ёсны хаяг, харилцах утас:

Газар ашиглуулагч:..... *Ховд аймал Зарви сум* .....  
*Газрын даалгач Б. Дорбо-ог* .....

Газар ашиглагч:..... *Улаанбаатар - 210646, Цэнгэлтэй сумд 4-р хороо, Бондгагийн талбай - 4-4, "Мэх Төмөр" сургууль төв, 10-дөрхүүт утас: 976-7011-0567* .....

Регистр /улсын бүртгэлийн/ дугаар.....

Харилцах дансны дугаар..... *5041064324 АРААН Банк* .....

Харилцах утас..... *976-7011-0567* .....

WWW.ILTODGEREEMN  
ЭХ СУРВАЛЖ

5.Гэрээ байгуулсан:


Газар өмчлөгчийг төлөөлж:


Газар эзэмшигч:

Дарви сум (дүүрэг)-ын  
газрын асуудал хариуцсан  
Албан тушаалтан  
Д. Түмэндэмбэрэл

Ховд аймаг (нийслэл)-ийн  
Дарви сум (дүүрэг)-ын  
Мөрөн баг (хороо)-ийн нутаг  
Дэвсгэрт орших "МОЭНКО" ХХК  
(аж ахуйн нэгж байгууллагын нэр)

захирал Г. Нацагдорж

  
\_\_\_\_\_ (нэр)  
(гарын үсэг)

  
\_\_\_\_\_ (нэр)  
(гарын үсэг)



Тамга

Тамга

Гэрээг улсын бүртгэлд 2009 оны 12-р сарын 2-ны өдөр бүртгэв.

Бүртгэсэн: \_\_\_\_\_ (нэр)  
(гарын үсэг)

ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN